

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум
Урл булаг баг, Ханддоржийн
удалж, Утас/Факс: 73351826
Цахим хуудал: www.oga.gov.mn
Холбоо: 6251294

Тайлан

№

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
М.ОТГОНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт угэх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол улсын Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 10, 11 дүгээр хавсралтуудыг тус тус үндэслэн 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Улсын бүртгэлийн ерөнхий газраас Орхон аймгийн улсын бүртгэлийн хэлтсийг 25 орон тоотой байхаар баталж, цалингийн санг 754,834.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс цалинждаг 4 ажилтны цалинд 35,840.0 мянган төгрөг,

Аймгийн ИТХ-ын 11/04 дүгээр Засгийн газрын 488 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдэлд 197.841.1 мянган төгрөгийн санхүүжилт, ерөнхийлөгчийн сонгуулийн ажлын зардалд 102.170.9 мянган төгрөгийг зарцуулахаар тус тус санхүүжилт олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг 96.67 хувьтай үнэлсэн.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ес зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл ниилээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ПНХРЭВЛХАГВА